



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 705

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус үндэслэн “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх байгууллага” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 1,707,809,330.00 (нэг тэрбум долоон зуун долоон сая найман зуун есөн мянга гурван зуун гуч) төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь

1.“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх байгууллага” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2023 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх байгууллага” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал (Б.Халиун)-д Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

3.“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх байгууллага” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал (Б.Халиун)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

3.1.Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх;

3.2.Тус үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, барилга байгууламжийн доорх газрыг Гадаад харилцааны яамнаас шилжүүлэн авах талаар санал боловсруулж, шийдвэрлүүлэх;

3.3.Үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн, 68,358,867.18 (жаран найман сая гурван зуун тавин найман мянга найман зуун жаран долоон төгрөг арван найман мөнгө) төгрөгийн эргэлтийн шинжтэй хөрөнгийг бараа материалын дансанд шилжүүлэх асуудлыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх;

3.4.Гадаад харилцааны яаманд үнэ төлбөргүй үзүүлж буй ажил, үйлчилгээг таслан зогсоож үйлдвэрийн газрын дүрмийн 3.2.6 дахь хэсэгт заасны дагуу тухайн төрийн захиргааны төв байгууллагын захиалгаар гэрээний үндсэн дээр, төлбөртэй ажил, үйлчилгээ үзүүлэх;

3.5.Төрийн өөрийн өмчийн түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлбэл зохих 18,705,909.00 (арван найман сая долоон зуун таван мянга есөн зуун ес) төгрөгийг 2024 оны 12 дугаар сард багтаан 1009 0000 0703 тоот дансанд төвлөрүүлэх;

3.6.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохих зөвшөөрлийг авч "Хилийн чанад дахь Монголчуудын холбоо" ТББ-д төрийн өөрийн өмчийн байр талбайг ашиглуулах.

3.7.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2024 оны 12 дугаар сарын 13-ны
өдрийн 105 дугаар тогтоолын хавсралт

“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх байгууллага”
төрийн өмчит үйлдвэрийн газарт хийсэн баримтын
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг
арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн (төгрөгөөр)	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Дээд шатны байгууллагыг санхүүжүүлсэн зардал	1,641,618,521.00	Засгийн газрын 2018 оны “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” 8 дугаар тогтоолын 2.2. дахь заалтыг мөрдөж ажиллах
2	Худалдан авах ажиллагааны журмыг буруу сонгосон	47,484,900.00	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 зүйлийн 10.3 дахь заалтыг мөрдөж ажиллах
3	Орон сууц, гарааш, зуслангийн байшин, албан тасалгаа, тээврийн хэрэгслийг иргэн, хуулийн этгээдэд түрээслүүлэн 93.53 сая төгрөгийн орлого олсон	18,705,909.00	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49, 50, 51 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах
Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн нийт дүн		1,707,809,330.00	(нэг тэрбум долоон зуун долоон сая найман зуун есөн мянга гурван зуун гуч) төгрөг